



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/36

Шивээговь сум

Асран хамгаалагчаар тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэр бүлийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.2, 65.1.3, 65.1.5, 67 дугаар зүйлийн 67.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1, 73 дугаар зүйлийн 73.2.4, сумын Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/60 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2 дугаар багийн иргэн Боржигон овогтой Тэгшбаярын Хос-Эрдэнэ /EY07241518/-ийн төрсөн эцэг, эх нь гэнэтийн ослоор нас барсан тул харгалзан үзэж төрсөн эгч болох Боржигон овогтой Тэгшбаярын Хосцэцэгийг асран хамгаалагчаар тогтоосугай.

2.Асран хамгаалагч Тэгшбаярын Хосцэцэгт хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх), 2 дугаар багийн Засаг дарга (С.Отгонбаатар) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.СУГАРМАА

